

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 03-р сарын 11-ний өдөр

Дугаар 03/01

Улаанбаатар хот

Тайлан, төлөвлөгөөг дүгнэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, "Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайланг хавсралт (Хавсралт 1)-аар баталж хангалттай гэсэн үнэлгээгээр дүгнэсүгэй.

Хоёр. Компанийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хавсралтаар (Хавсралт 2)-аар баталж хангалттай гэсэн үнэлгээгээр дүгнэсүгэй.

Гурав. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хавсралт (Хавсралт 3)-аар баталж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.

Дөрөв. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг хавсралт (Хавсралт 4)-аар баталсугай





“ДСЦТС” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 03/01 тоот тогтоолын Хавсралт 3

**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААР КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ГАРГАСАН ДҮГНЭЛТ**

2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

1. ДСЦТС ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлангийн үр дүн, 2021 оны жилийн санхүүгийн аудитлагдсан тайланг Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) хэлэлцээд ТУЗ-ийн өмнө хүлээсэн үүргээ ерөнхийд нь хангалттай биелүүлсэн гэж дүгнэв.
2. Цаашид дараах зүйлийг анхааран ажиллахыг Компанийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай. Үүнд:
  - 2.1 2022 оныг хэрэглэгчдэд ойртох, өр авлага бууруулах жил болгон ажиллаж, ихээхэн авлагатай хуулийн этгээдүүдийн авлагыг бууруулах;
  - 2.2 Компанийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөвт зардлын гүйцэтгэл хэтэрч болзошгүй нөхцөл байдал үүсвэл ТУЗ-д урьдчилан танилцуулж, хэлэлцүүлэн тогтоол гаргуулан тухай бүр шийдвэрлүүлж байхыг Компанийн Дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Б.Батжаргал болон Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан Л.Эрдэнэсугар нар анхаарч ажиллах;
  - 2.3 Энэ жил Эрчим Хүчний Зохицуулах Хороонд хүргүүлэх тарифийн саналд Компанийн тодорхой хэмжээний ашигтай ажиллуулахаар төлөвлөн ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулах;
  - 2.4 Үйл ажиллагааны чиглэлээр гаргах ТУЗ-ийн тогтоолуудын гүйцэтгэлийг тухай бүр тайлагнаж ажиллах.



ТУЗ-ИЙН АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

*Л.Балган*

Л.БАЛГАН

## ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03-р сарын 11-ний өдөр

Дугаар 03/02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 11 цагт "Хасвуу" плазагийн хурлын танхимд хуралдуулсугай.

Хоёр. Хурлаар дараах асуудлыг хэлэлцсүгэй: (i) Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; (ii) Компанийн 2021 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах; (iii) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох; (iv) Компанийн ТУЗ-ийн 2022-2023 оны ТУЗ-ийн цалин урамшуулал болон зардлыг батлах.

Гурав. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоосугай.

Дөрөв. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоон, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Тав. Саналын хуудасны агуулгыг хавсралт 1-ийн дагуу батасугай. Саналын хуудсыг авах сүүлчийн өдрөөр 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр байхаар тогтоосугай.

Тав. Хувьцаа эзэмшигчид нь Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2021 оны үйл ажиллагааны тайлан, Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад мэдээлэлтэй танилцаж болно.

Зургаа. Хурлын даргаар Ц. Баярбаатарыг томилсугай. Тооллогын комиссын даргаар М.Баярманла, гишүүнээр Л.Балган нарыг тус тус томилсугай.

ДАРГА



Ц.БАЯРБААТАР